

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Аймгийн Засаг дарга нартай 2017 онд хамтран ажиллах гэрээг 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. Нийт 21 аймгийн Засаг дарга гэрээний биелэлтээ албажуулан ирүүлсэн бөгөөд гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **84.2** хувьтай. /хүснэгт-1/

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран
ажиллах гэрээний биелэлтэнд өгсөн үнэлгээ /2017 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

[illegible]

ДҮГНЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Тухайн аймагт геологи хайгуул болон газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг харгалзан үзэж хамтран ажиллах гэрээг байгуулах;

2. Ашигт малтмал эрэх хайх талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн саналд хууль тогтоомжийн дагуу хариу шуурхай хүргүүлэх арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа Төв, Завхан, Булган, Дархан-Уул зэрэг аймгууд орон нутагт хэдэн санал ирсэн, хэдэн саналыг дэмжсэн болон дэмжээгүй талаар тодорхой тоон мэдээллийг тусгаагүй байна.

3. Зарим аймгийн Засаг дарга нар хамтран ажиллах гэрээг тайлагнахдаа тухайн заалтад дурдсан арга хэмжээнд хамааралгүй арга хэмжээг тоочих, заалтын хүрээнд хийсэн ажлын хэмжээ харагдахгүй хэт ерөнхийлөн бичих, тухайн заалтыг биелэлтийг өнгөрсөн цаг дээр болгож хуулбарлан бичих, аль суманд ямар аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй байх зэрэг зөрчлүүд илэрч байна.

4. Ихэнх аймгуудад Гэрээний дараах заалтууд болон тус заалтуудын зарим хэсэг хэрэгжээгүй байна. Тодуулбал, 3.2.5-д: "Ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хууль бусаар зогсоох, үйл ажиллагаанд нь саад учруулахгүй байх талаар сум, орон нутгийн ИТХ, Засаг дарга, иргэдэд уламжлах, танилцуулах", 3.2.11-д: "Газар олголтыг зохион байгуулахдаа хүнд үйлдвэр байгуулах боломжтой байршлыг төлөвлөх, нөөцөд авах, 3.2.14-т: "ЗГ-ын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан "Ашигт малтмалын ТЗ эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах гэрээ" аймгийн хэмжээнд ТЗ эзэмшигчидтэй байгуулах", 3.2.16-д: "Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бусад асуудлаар орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах" заалтууд тус тус хамаарч байна.

5. Орхон аймгийн Засаг даргаас ирүүлсэн гэрээний биелэлтийг дүгнэхэд бусад аймагтай харьцуулахад хангалтгүй байна. Тухайлбал, гэрээний 16 заалтаас тухайн заалтын хүрээнд огт хамааралгүй биелэлт тоочсон 7 заалт байна.

6. Дорноговь аймгийн Засаг дарга гэрээний загварын дагуу хүснэгтээр тайлагнах шаардлагатай байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хамтран ажиллах гэрээний биелэлтэд ач холбогдол өгч, гэрээний заалт бүрээр хийсэн ажил, биелэлтийг оновчтой, тодорхой, хэрэгжүүлсэн субъект, албан бичиг хүргүүлсэн огноо, дугаартайгаар үнэн зөв гаргаж хэвших.
2. Гэрээний заалтад хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах
3. Тухайн зорилт, арга хэмжээний гол үр дүн, хүрсэн түвшин, төлөвлөсөн асуудалтай уялдуулж ажлаа тайлагнах тал дээр анхаарч ажиллах.
4. Уул уурхайн салбар нь улсын төсвийн голлох хэсгийг бүрдүүлдэг тул хамтран ажиллах гэрээг байгуулахдаа дээр дурдсан алдаа дутагдлыг дахин гаргуулахгүй байхад анхаарах, яамны нэгжүүд болон ХШУДАГ-ын гэрээний төсөлд өгсөн саналыг тусгах зэрэг асуудалд Төрийн захиргааны удирдлагын газар анхаарч ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Ц.Одхүү

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХШУДАГ-ын мэргэжилтэн:

С.Цэцэг-Өлзий /2018.03.23/